



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 0/236

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.5.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Арвайхээртээ англи хэл сурцгаая” хөтөлбөрийн сургалтын зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 11,360,000 (арван нэгэн сая гурван зуун жаран мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0447

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр  
сарын 17-ны өдрийн 036 дугаар  
захирамжийн хавсралт



“АРВАЙХЭЭРТЭЭ АНГЛИ ХЭЛ СУРЦГААЯ” ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВ

№	Арга хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүр	Нийт
1	Филиппин улсад сургалтад хамрагдах 1 шилдэг оролцогчийн замын зардалд	1	3,000,000	3,000,000
2	Асртид апп-ын 6 сарын эрх авах зардалд	130	20,000	2,600,000
3	Багш нарын урамшуулалд	8	720,000	5,760,000
Нийт				11,360,000

-оОо-